

ХУРАЛДААНЫ ТОЙМ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2016 ОНЫ АНХДУГААР ХУРАЛДААН

Хуралдаан 2016 оны нэгдүгээр сарын 07-ны 14 цаг 05 минутад эхэлж, 14 цаг 39 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 34 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Санхүүгийн зохицуулах хорооны Бүртгэл, зөвшөөрлийн газрын Хяналт үйлчилгээний хэлтсийн даргын сонгон шалгаруулалтын тайлан, уг албан тушаалд томилогдох ажилтанд дүгнэлт гаргах тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 32, 39 дүгээр зүйлүүдийг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн хуралдааны шийдвэр, дүгнэлтийг үндэслэн:</p> <p>Амарын Төгс-Эрдэнийг Санхүүгийн зохицуулах хорооны Бүртгэл, зөвшөөрлийн газрын Хяналт, үйлчилгээний хэлтсийн даргын албан тушаалд томилогдох төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцөд бүртгэж, уг албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлэн Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны дарга Б.Батсэлэнгэд санал болгох Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
2	Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн даргын сонгон шалгаруулалтын талаар танилцуулах	<p>Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны нээлттэй сонгон шалгаруулалтыг 2016 оны нэгдүгээр сарын 7-ноос эхлэн Төрийн албаны зөвлөлийн csc.gov.mn сайтаар нийтэд, нээлттэй дахин зарлаж, сонгон шалгаруулалтыг 2016 оны 2 дугаар сарын 02-ны өдөр зохион байгуулахаар шийдвэрлэлээ.</p>
3	Бусад асуудал /Хөдөлмөрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гааль, татварын ерөнхий газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны нээлттэй	<p>Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Баярцогтын 2016 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн ХЭГ/13 тоот албан бичгээр Хөдөлмөрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг</p>

	сонгон шалгаруулалт зарлах тухай	эрхлэх газрын дарга С.Баярцогтын 2016 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн ХЭГ/24 тоот албан бичгээр Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гааль, татварын ерөнхий газрын даргын албан тушаалд тус тус томилогдох удирдах ажилтны нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах захиалга ирүүлснийг хэлэлцээд, сонгон шалгаруулалтыг 2016 оны 2 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн, Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд, нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг 2016 оны 2 дугаар сарын 02-ны өдөр зохион байгуулахаар шийдвэрлэлээ.
--	----------------------------------	--

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА